


Хаврын улиралд цаг агаар тогтворгүй байдагтай холбоотой агаарын температурын хэлбэлзэл ихэсдэг. Манай орны 4 дүгээр сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон томоохон гол, нуурын сав газраар 0°C (32°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар +6°C (42.8°F) –аас +12°C (53.6°F), бусад нутгаар 0°C –аас +5°C (32°F – аас 41°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 4 дүгээр сард хур тунадас бага унадаг ба ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 3 хувьтай тэнцдэг. Тус сард Булган, Хөвсгөлийн зүүн хойд хэсгээр 10-17 мм, Ховд, Говь-Алтай болон нутгийн өмнөд хэсгээр 0.2-4.9 мм бусад нутгаар 5.0-10 мм тунадас ордог байна .



Зураг 1. 1991-2020 оны 4 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2025 оны 4 дүгээр сарын агаарын дундаж температур өмнөх жилээс 0.6°C-аар, ОЖД-аас 2.2°C-аар тус тус дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 4 дэх дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгаар дунджаас 1.0–ээс 3.5°C-аар дулаан байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 3.88 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 2 дахин, ОЖД-аас 31.7%-иар тус тус бага бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 22 дахь бага тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 71.3% нь дунджаас бага, 22.5% нь ахиу, 6.2% -д дунджийн орчим хур тунадас унасан байна.




Зураг 2. 2025 оны 4 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын газарзүйн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 4 дүгээр сарын хоногийн агаарын дундаж температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) 1 болон 2 дугаар 10 хоногийн ихэнх хугацаанд нийт нутгаар ОЖД-аас 1.1-ээс 11.4°C-аар дулаан, 2 дугаар 10 хоногийн эхэнд төв, өмнө, зүүн бүс нутгаар дунджаас -0.3-ээс -6.7°C-аар хүйтэрч ажиглагдсан байна. Харин 3 дугаар 10 хоногт дийлэнх нутгаар температурын хэлбэлзэл ихтэй байжээ. Хур тунадасны хувьд 2 дугаар 10 хоногт ихэнх нутгаар, 3 дугаар 10 хоногт зөвхөн зүүн бүс нутгаар харьцангуй ахиу хур тунадас тус тус орсон байна.



Зураг3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Энэ сард агаарын температурын үнэмлэхүй их утга Сэлэнгийн аймгийн Орхон суманд 30.5°C, үнэмлэхүй бага утга Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -22.2°C хүрчээ. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Эхийнголд 54°C, үнэмлэхүй бага утга Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -23°C хүрч хүйтэрсэн. Хоногт хамгийн ихдээ Баян-Өлгий аймгийн Дөчинжил суманд 17-ны өдөр 13.9 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 953гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 763.2гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Баянхонгор аймгийн Баянцагаан суманд 37 м/с хүрчээ.



Зураг 4. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд